

"Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбар"-ын

танилцуулга **2018**

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	4
Зургийн жагсаалт	4
Үүсэл хөгжил, танилцуулга	5
Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын талаар	8
Дотоодын нийт бүтээгдэхүүн	10
Аж үйлдвэрийн салбар	12
Барилга	14
Тээвэр, Холбооны салбар	15
Дүгнэлт	19
Санал	20

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Статистикийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн У.Хоролмаа

Хаяг: Нутгийн Удирдлагын ордон 304 тоот

Утас: 70533439, 70533061

Цахим хаяг: umnugovi@nso.mn

Веб хаяг: www.umnugovi.nso.mn

www.1212.mn

Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс

Даланзадгад 2019 он

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

1. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА бүс, аймаг, нийслэлээр 2010-2018 он
2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА бүс, аймаг, нийслэлээр 2010-2018 он
3. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ХОРШОО, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ГИШҮҮДИЙН ТОО, бүс, аймаг, нийслэлээр
4. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр, оны үнээр* 2015-2018 он
5. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2014-2018 он, оны үнээр, мян.төг
6. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2014-2018 он биет хэмжээгээр
7. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг
8. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
9. АВТО ТЕХНИКИЙН УЛСЫН ҮЗЛЭГ
10. ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

1. НИЙТ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО 2010-2018
2. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН 2015-2018 ОНООР /сая төг/
3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД /салбаруудын эзлэх хувь/
4. НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН / сая.төг/
5. АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, 2014-2018 оноор, оны үнээр, сая.төг
6. АРХИ СОГТУУРУУЛАХ УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2014-2018 он, мян.л
7. СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2014-2018 он, мян.л
8. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг
9. АВТО МАШИНЫ УЛСЫН ҮЗЛЭГИЙН ДҮН 2016-2018 он /бүтцээр/
10. АВТО МАШИНЫ УЛСЫН ҮЗЛЭГИЙН ДҮН 2016-2018 он
11. ХОЛБООНЫ САЛБАРЫН НИЙТ ОРЛОГО 2015-2018 он сая.төг
12. ТЕЛЕФОН ЦЭГИЙН ТОО 2015-2018 он

АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ТАНИЛЦУУЛГА

Манай аймаг анх 1931 оны өнт хонин жилийн хавар 2-р сард Өмнөговь аймаг байгуулагдаж, хацрын ар усанд түр байрлаж байсан худалдааны жижиг салбарыг нүүлгэн далангийн голын ард буулгаж аймгийн хоршоо болгон ашиглаж Лхагва, Дандар нарын 2 орон тоотойгоор ажиллуулсан нь худалдаа эрхлэгчдийн хоршооны тус аймаг дахь үндэс суурь нь болсон ба энэ хоршоо нь тухайн үеийн ханшаар 20 гаруй мянган төгрөгийн бараатай 2 эсгий гэртэй байв.

Энэ үеээс хойш аймгийн нийт сумдад хоршоо худалдааны салбарууд байгуулагдаж хөдөө нутгийн олон ардуудыг анхны хоршооны гишүүнээр элсүүлж, тусгай хэвлэмэл үнэмлэх олгож, тэдэнд зарим төрлийн хөнгөлөлт эдлүүлэх зэрэг ажил зохиогдож байв. Үүний зэрэгцээ ХАА-н үйлдвэрлэлд аян жин тээх, малын хашаа барих, худаг ус гаргах, ан агнах, хадлан тэжээл бэлдэх зэрэг ажилд хүч хөдөлмөрөө хамтран ажиллах зайлшгүй шаардлага гарч байв. Энэ шаардлагын дагуу Мандал-Овоо, Баяндалай, Ноён сумын зарим ардын аж ахуйтан хөдөлмөрөө хорших санаачлага гаргаж. 1937 онд Мандал-Овоо сумын ард Чосров, Даваа нар санаачлан 17 хүн сайн дураараа санал нэгдэн “Ангийн нөхөрлөл байгуулж, хамтын хүчээр ан агнаж мах, арьсыг нь худалдаанд тушааж орлогоо хувааж авдаг болсон байна. Мөн 1939 оны намар Ноён сумын малчин ард М.Даваа тэргүүтэй 5 малчин хамтран Дов сүүжийн булгийн түшиглэн жингийн нөхөрлөл байгуулж байсан нь одоогийн Гурван тэс сумын “Соёл” Нэгдлийн суурь нь байсан юм. Мөн 1930 аад оны дундуур байгуулагдсан үйлдвэрлэлийн хоршоодын артелиуд өргөжин тэлсээр байсан бөгөөд аймгийн төвийн артель 1950 иад оны дунд үеэс гар үйлдвэрлэлийн хоршооллын артель болон өргөжиж байв.

Улмаар 1990 оноос хойш зах зээлийн нийгэмд шилжин орчин цагийн буюу шинэ үеийн үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа барилгын салбарын үндэс тавигдсан байна.


“Таван толгойн уурхай”-н түүхэн замнал

Хуучин Түшээт хан аймгийн Говь-Түшээ” гүний хошууны “Их Шанхай” уулын ойролцоо одоогийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Сийрт” багийн нутаг “Өгөөмөр” уулын баруун хойд үзүүрт “Цэций” уулын ард таван жижиг толгодын нэрээр нэрлэгдэн тогтсон Тавантолгой нүүрсний орд нь 8 аймгийнхаа төвөөс 96 км, сумаасаа 14 км, Улаанбаатар хотоос 550 км, Дорноговь аймгийн төмөр замын Сайншанд өртөөнөөс 470 километрийн зайд оршдог. Тавантолгойн нүүрсний орд нь, эрт дээр үеэс энгийн байдлаар хөрсөнд ил гарч, ардын хувьсгалын жилүүдэд ЗХУ, болон социалист бусад улс орны ба өөрийн орны геологичдын хамтарсан шинжилгээ судалгаагаар нээгдсэн дэлхийд алдартай коксжих нүүрсний том орд газар юм. 1934-1935 оноос, энд чулуун нүүрс байдаг гэдгийг ажил хичээнгүй ажигч гярхай нутгийн ардууд, ахмад буурлууд, уран дархчуул тухайн үедээ мэдэж, амьдрал ахуйдаа тэмээнд нуруу ачаалан хэрэглэж, үр дүнгий нь үзсэнээс улбаалан 1936 оноос сум, аймгийн хамгаалалтанд авч, гар аргаар түлшинд хэрэглэж эхэлсэн байна. 1939 оны сүүлч 1940- оноос эхлэн Цогтцэций сум дахь үйлдвэр-хоршооллын артельд Тавантолгойн чулуун нүүрсийг шилжүүлэн, гар аргаар гарган авч аймгийн төвд борлуулж эхэлснээр анхныхаа ажил үйлчилгээний гараанд гарч улмаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1966 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор тус орд газрыг улсын болгож, үйлдвэрийн аргаар ашиглахаар шийдвэрлэн Аж Үйлдвэрийн Яаманд шилжүүлэн өгч, Дундговь аймгийн Цагаан-Овоогийн нүүрсний уурхайн цэг болгон ажиллагчид 8, үүнээс ажилчид гуравтайгаар зохион байгуулагдаж, анх удаа 3000 тн нүүрс гаргаж борлуулах улсын төлөвлөгөөг

хүлээн авч ажиллажээ. Улмаар аж үйлдвэрийн яамны 1967 оны 4-р сарын 25-ны өдрийн 64 тоот тушаалаар Сайд нарын Зөвлөлийн 30-р тогтоолыг үндэслэн 1967 оны 5-р сарын 1-ний өдрөөс биеэ даасан уурхайн захиргаа болгон байгуулсан байна. Энэ үед нийт 15 ажиллагсадтай, үүнээс ажилчид 6, инженер 3-302-нэг, ЖЭС-60, дизель станц-нэг, үйлчилгээний ГАЗ-53 машин-нэг, ус зөөврийн ЗИЛ-164 цистерн-нэг, конторын эсгий гэр-нэг, ажилчдын сууцны эсгий гэр-тав бүгд -230.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр ирж байрласан бөгөөд анхны даргаар Цагаан-Овоогийн нүүрсний уурхайд мастераар ажиллаж байсан, Ханбогд сумын харьяат Сэрээтэрийн Хүүхэнжав томилогдоножиллажээ. Ийнхүү анхныхаа жилд 4300 тонн нүүрс гаргаж борлуулах, 1500 м³ хөрс хуулах улсын төлөвлөгөөт даалгавар хүлээн авч 107.2-133.3 хувиар биелүүлсэн бахдам сайхан амжилтаар гараагаа эхэлсэн байна. 1978-1980 онуудад уулын үндсэн тоног төхөөрөмжүүд шинэчлэгдэн Э-10011 энкскаватор, краз-256 автосамосвал, СБВ-2 м өрмийн машин, ЭСД-100 дизель станцуудаар хангагдаж байсан бол 1980-1990-ээд онд ЭО-5111 экскаваторууд, автогрейдер. Т-170, Т-130 бульдозерууд зэргээр уулын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэн, автопарк үйлчилгээний машин техникүүдээр шинэчлэгдэн жилдээ 120000 тн нүүрс олборлон борлуулах хүчин чадалтай орон нутгийн чанартай томоохон уурхай болон өргөжсөн байна.

Монгол Улсын Засгийн Газраас орон нутгийн уурхайнуудыг өргөтгөх хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд болон Даланзадгадын Дулааны Цахилгаан станц ашиглалтанд орсноор уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор 2000 оноос коматцу Д-65 бульдозер. РС-220 экскаватор, 25 тн-ийн даацтай терекс автосамосвал 2 ш зэргээр парк шинэчлэлтийг дахин хийснээр өнөөдөр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Манай уурхайн хамт олон, түүхийн 40-н жилийн хугацаанд Өмнөговь аймгийн нийт сум, төвийн хэрэглэгчид, Дорноговь аймгийн хилийн залгаа сумдууд, цэргийн анги, Дундговь аймгийн төв болон ойрын сумдын нүүрсний хэрэгцээг хангаж ирсний зэрэгцээ 1990-1991 онд Хөтлийн цемент шохойн үйлдвэр, Улаанбаатар хотын 3-р цахилгаан станцад нүүрс нийлүүлж байснаас гадна 2004 оноос БНХАУ-д нүүрс экспортлох гэрээ хийснээр 2006 он гэхэд хугацаанд нүүрс борлуулалтын хэмжээ эрс нэмэгдэж нийт 2.8 сая тн нүүрс олборлож, 2.9 сая тн хөрс хуулсан амжилттай байна. 2001 оноос эхлэн манай аймагт олон томоохон уурхайнууд шинээр бий болж аймгийн тэргүүлэх салбар болон хөгжсөөр байна.

1. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ,



БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР

Монгол улсад нийт бүртгэлтэй 174936 аж ахуйн нэгж, байгууллага байгаанийн 1.6 хувь, төвийн бүсийн 17.6 хувийг Өмнөговь аймгийн аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна. / ХҮСНЭГТ 1/

ХҮСНЭГТ 1. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА бүс, аймаг, нийслэлээр 2010-2018 он

Аймаг, нийслэл	2010	2015	2016	2017	2018
Улсын дүн	73 795	126560	141502	155065	174936
Төвийн бүс	7 685	11700	12587	13804	15516
Говьсүмбэр	196	351	398	439	469
Дархан-Уул	2170	3196	3480	3768	4000
Дорноговь	705	1181	1298	1439	1640
Дундговь	571	861	907	965	1071
Өмнөговь	862	1797	1966	2256	2731
Сэлэнгэ	2020	2528	2619	2894	3411
Төв	1161	1786	1919	2043	2194

ХҮСНЭГТ 2.ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА бүс, аймаг, нийслэлээр 2010-2018 он

Аймаг, нийслэл	2010	2015	2016	2017	2018
Улсын дүн	40 951	64301	72182	78585	87725
Төвийн бүс	4 821	7862	8499	9050	9724
Говьсүмбэр	159	278	313	302	374
Дархан-Уул	1032	1811	1973	2130	2198
Дорноговь	460	922	1002	1069	1192
Дундговь	401	585	601	639	671
Өмнөговь	587	1109	1281	1429	1673
Сэлэнгэ	1562	2032	2108	2214	2300
Төв	620	1125	1221	1267	1316

2018 онд бизнес регистрийн санд бүртгэлтэй 2731 аж ахуйн нэгж, байгууллагаас үйл ажиллагаа явуулж байгаа нь 1673 байна. Бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 2010 оноос 1869 буюу 3.1 дахин, өнгөрсөн оноос 244 буюу 17.1 хувиар тус тус өссөн байна. Дээрх бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо өссөнтэй

уяалдаатайгаар мөн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо жил ирэх тусам өсөлттэй байна. /ХҮСНЭГТ 1/, /ХҮСНЭГТ 2/, /ЗУРАГ 1/

ЗУРАГ 1. НИЙТ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО 2012-2018 он



2017 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хэмжээнд бизнес регистрийн санд бүртгэлтэй 4377 хоршоо, төвийн бүсэд 756, Өмнөговь аймагт 90 хоршоо байна. Энэ нь өмнөх оныхоос 1 хоршоогоор нэмэгдсэн бөгөөд 4120 гишүүдтэй байна.

БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ХОРШОО, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ГИШҮҮДИЙН ТОО, бүс, аймгаар

ХҮСНЭГТ-3

Аймаг, нийслэл	Хоршоо		Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, сая төг		Гишүүдийн тоо	
	2016	2017	2016	2017	2016	2017
Улсын дүн	4254	4377	41540.3	42457.6	147138	149154
Төвийн бүс	746	756	4897.3	5106.4	25492	25612
Говьсүмбэр	19	22	151.3	152.4	634	664
Дархан-Уул	123	125	1451.9	1412.2	1523	1561
Дорноговь	67	67	499.2	499.2	3141	3141
Дундговь	101	101	772.4	772.9	5569	5577
Өмнөговь	89	90	281.4	282.5	3396	3405
Сэлэнгэ	168	169	632.3	875.5	4106	4120
Төв	179	182	1108.6	1111.7	7123	7144

2. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН



Урьдчилсан гүйцэтгэлээр 2018 онд Өмнөговь аймаг Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.9 хувь, төвийн бүсийн 19.5 хувь болох 597.3 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагийн дээр нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 8.8 сая төгрөг болж улсын хэмжээнд Орхон аймаг, Улаанбаатар хотын дараа 5-т, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дүнгээр 287.9 тэрбумд хүрч Улаанбаатар, Орхон аймгийн дараа 5-т тус тус орж байна.

ХҮСНЭГТ 4. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр, оны үнээр* 2012-2018 он


	2015				2016			
	ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Дүн	23150385.6	13.3	33.7	53.1	23 942 866.4	11.5	36.6	51.8
Төвийн бүс	2348241.3	35.1	29.4	35.5	2 439 043.8	29.7	35.2	35.2
Говьсүмбэр	83724.4	25.8	30.7	43.5	83 354.9	20.0	38.3	41.7
Дархан-Уул	367262.7	9.8	40.9	49.2	387 260.4	9.7	42.1	48.2
Дорноговь	261319.1	36.0	8.0	56.0	272 288.4	25.6	18.1	56.4
Дундговь	237565.8	60.1	11.9	28.0	226 072.5	55.1	14.1	30.7
Өмнөговь	281273.5	32.8	20.9	46.3	404 035.8	22.5	42.9	34.7
Сэлэнгэ	574519.5	25.0	47.7	27.2	555 423.0	23.9	48.1	28.0
Төв	542576.3	54.0	24.4	21.6	510 608.8	49.4	27.6	23.0
	2017				2018**			
	ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Дүн	27 876 297.2	10.1	41.4	48.5	32 093 615.4	10.8	41.6	47.6
Төвийн бүс	2 870 828.4	25.0	41.9	33.2	3 068 821.3	31.7	34.9	33.4
Говьсүмбэр	83 959.4	20.8	38.0	41.2	91 702.8	21.3	33.7	45.0
Дархан-Уул	409 544.4	8.2	46.3	45.6	435 751.1	10.0	43.9	46.0
Дорноговь	296 014.8	27.3	17.4	55.3	349 617.2	32.9	17.3	49.8
Дундговь	258 177.0	56.7	14.7	28.6	319 543.6	61.0	15.0	24.0
Өмнөговь	714 470.2	14.7	57.5	27.8	597 384.9	21.7	40.7	37.6
Сэлэнгэ	598 216.1	20.9	51.2	27.9	680 615.3	27.0	47.1	25.9
Төв	510 446.5	40.9	34.0	25.0	594 206.5	48.0	29.7	22.2

* Нөөц, ашиглалтын хүснэгтийн 2014 -2016 оны үр дүнгээр тодотгоов.

** Урьдчилсан гүйцэтгэл


Өмнөговь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2014-2015 онуудад нэлээд бууралттай байсан боловч 2016-2017 онуудад тогтвортой өсөлттэй байгаа нь дараах графикаас тодорхой харагдаж байна. / ЗУРАГ 2/

ЗУРАГ 2. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН 2014-2018 ОНООР /сая төг/



Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар нь авч үзвэл: Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар 21.7 хувь, Аж үйлдвэр, барилгын салбар нь 40.7 хувь, Үйлчилгээний салбар 37.6 хувийг тус тус эзэлж байна. /Хүснэгт 4/, /Зураг 3/

ЗУРАГ 3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД /салбаруудын эзлэх хувь/




Нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2014 онд 5.6 сая, 2015 онд 4.6 сая, 2016 онд 6.4 сая, 2017 онд 11.0 сая, 2018 онд 8.8 сая төгрөгт хүрсэн байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2016 оноос 2.4 сая төгрөгөөр өсч, харин өнгөрсөн оноос 2.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна./Зураг 4/

Зураг 4. НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН / сая.төг/



3. АЖ ҮЙЛДВЭР




2018 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2361.1 тэрбум төгрөг болж 2014 оноос 5.4 дахин буюу 1924.5 тэрбум төгрөгөөр өссөн байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 86.1 хувиар буюу 1092.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. /Хүснэгт-5/ /ЗУРАГ 5/

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувиар нь авч үзвэл: уул, уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалт 99.9 хувь буюу 4172.4 тэрбум төгрөгийн эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2014-2018 он, үнийн дүнгээр

Бүтээгдэхүүний нэрс	Үнийн дүнгээр (мян.төг)					<u>2018</u> <u>2017</u>
	2014	2015	2016	2017	2018	
Чулуун нүүрс	431184237.2	361337455.1	705142136.1	1264798536	2356963660	186.4
Алт	93252.5	0	253346.5	0	0	
Дулааны эрчим хүч	2183701.9	2463245.9	2470555	2524017.5	2764798.5	109.5
Хиамны зүйл	338027.7	183019	70863.8	0	0	
Боловсруулсан шингэн сүү	180689.2	119677.8	72313.7	96220.1	120155	124.9
Нарийн боов	20502.2	116828.2	235139.5	13339.5	5292.3	39.7
Архи	370323.5	324750.8	299512.7	227176.3	336477.3	148.1
Түгээсэн цэвэр ус	502216.9	548483.2	613450.1	624383.5	569209.1	91.2
Сувагжуулалт	270698	318673	373435.6	400116.2	376563.4	94.1
Бүгд	436555542.5	366761382.6	709530753	1268683789	2361136156	


ЗУРАГ 5. АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, 2014-2018 оноор, оны үнээр, сая.төг




ХҮСНЭГТ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2014-2018 он биет хэмжээгээр

Бүтээгдэхүүний нэрс	Хэмжих нэгж	Биет хэмжээ					<u>2018</u> <u>2017</u>
		2014	2015	2016	2017	2018	
Чулуун нүүрс	мян.тн	7880.3	9771.2	17691.2	22884.8	20844.3	91.1
Алт	кг	1.4		3.1			
Дулааны эрчим хүч	мян.Гкал	40.1	43.5	50.1	50.6	59.0	116.6
Хиамны зүйл	тн	67.6	34.7	14.6			
Боловсруулсан шингэн сүү	мян.л	63.8	47.3	28.8	43.8	48.00	109.6
Нарийн боов	тн	8.5	47.9	118.6	7.5	2.85	38.0
Архи	мян.л	18.7	12.9	12	9.6	12.5	130.2
Түгээсэн цэвэр ус	мян.м3	221.4	228.1	253.1	272.6	245.4	90.0
Сувагжуулалт	мян.м3	155.1	169.3	195.6	213.9	203.9	95.3

ЗУРАГ 6. ЧУЛУУН НҮҮРС ОЛБОРЛОЛТ, 2014-2018 он, мян.тн



ЗУРАГ 7. СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2014-2018 он, мян.л



4. БАРИЛГА




Барилга угсрат их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам гүүр, далан угсрах зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэгдсэн үйл ажиллагааг ойлгоно.

ХҮСНЭГТ 7. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг

	2015	2016	2017	2018
Улсын дүн	2946448.8	2928735.2	2926822.1	4009817.5
Төвийн бүс	419994.6	443219.8	821381.4	1417255.0
Говьсүмбэр	17572.4	10689.8	3802.1	3423.1
Дархан-уул	57374.9	79659.2	38812.8	91114.5
Дорноговь	28878.8	17046.2	95213	423281.8
Дундговь	21406.3	11230.2	8003.1	9515.0
Өмнөговь	226438.2	295485.2	562661.7	732711.8
Сэлэнгэ	35177.7	9146.0	83716.1	13216.6
Төв	33146.2	19963.1	29172.6	143992.2

Барилга угсралт, их засварын ажилд Өмнөговь аймаг 2018 онд 732.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийсэн нь 2017 оноос 1.3 дахин өсч бүсийн дүнд 51.7 хувь, улсын дүнд 18.3 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 8. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг



5.ТЭЭВЭР, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО, РАДИО ЦЭГИЙН ТОО ТЭЭВЭР ҮЙЛЧИЛГЭЭ



Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүдэд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, авто машины тоо, шилжүүлсэн тонн.км, ажиллагсдын тоо орлого зэрэг орно.

Авто тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгжүүдээс аймгийн статистикийн хэлтэс цуглуулан авч нэгтгэн Улсын бүртгэл

статистикийн ерөнхий газарт дамжуулдаг.

Тээсэн ачаа эргэлт: Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч тээвэр эргэлт: Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн хэмжээ

2018 онд 14.5 мян.тн ачаа тээвэрлэж, 4355.3 мян.тн.км-ийн ачаа эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос тээсэн ачаа 423 мян.тн-оор буурч, ачаа эргэлт 15 дахин буурсан гүйцэтгэлтэй байна. Тээвэр бүхий байгууллагууд 2859.7 мян.хүн тээвэрлэж, 90036.4 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос Зорчигч тээвэрлэлт 117.5 хувиар буюу 1544.9 мян.хүнээр өсч, зорчигч эргэлт 47.7 хувиар буюу 82225.2 мян.хүн.км-ээр буурсан гүйцэтгэлтэй байна. Тээврийн орлого 8595.1 сая төгрөг болж өнгөрсөн оноос 32.5 хувиар буюу 4130.7 сая төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 8. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих	2016	2017	2018	2018
	нэгж		11		2017
Ачаа эргэлт	мян.тн.км	28307.3	65206.6	4355.3	-
Тээсэн ачаа	мян.тн	425.25	437.5	14.5	-
Зорчигч эргэлт	мян.хүн.км	117886.4	172261.6	90036.4	52.3
Үүнээс: дотоодод	мян.хүн.км	117886.4	172261.6	90036.4	52.3
Тээсэн зорчигч	мян.хүн	973.3	1314.8	2859.7	217.5
Үүнээс: дотоодод	мян.хүн	973.3	1314.8	2859.7	217.5
Тээврийн орлого	сая.төг	13058.5	12725.8	8595.1	67.5
Тээврийн ажиллагсад	хүн	276	466	386	82.8


ХҮСНЭГТ 9. АВТО ТЕХНИКИЙН УЛСЫН ҮЗЛЭГ

Аймаг нийслэл	2016	2017	2018	Үүнээс:						
				Төрлөөр			Ашигласан хугацаагаар			
				суудлын	ачааны	автобус	тусгай зориулалтын	3 жил хүртэл	4-9 жил	10-аас дээш
Бүгд	499 152	536 399	585363	426065	131573	18570	9155	11666	120512	453185
Төвийн бүс	54206	60 425	67905	41164	22902	2361	1478	613	12937	54355
Говьсүмбэр	2 269	2 333	2311	1686	499	67	53	12	305	1 994
Дархан-Уул	9 725	9 152	8941	5970	2500	341	130	40	989	7912
Дорноговь	9 268	11 155	11909	8185	2972	414	338	111	1 393	10405
Дундговь	2 961	2 954	2818	1677	872	216	53	26	224	2568
Өмнөговь	13441	16 487	22700	12625	8584	765	726	339	7961	14400
Сэлэнгэ	8 404	10 403	11219	6767	4037	291	124	69	1320	9830
Тов	8 138	7 941	8007	4254	3438	267	48	16	745	7246

Эх үүсвэр: Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын мэдээлэл


Улсын хэмжээний нийт 585.4 мянган авто машины 3.9 хувийг манай аймагт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэлж байна. Манай аймгийн хэмжээнд 2018 онд авто техникийн улсын үзлэгээр бүх төрлийн авто машин 22700 болж өнгөрсөн оноос 37.7 хувиар буюу 6213 тээврийн хэрэгслээр өссөн байна.

ЗУРАГ 9. АВТО МАШИНЫ УЛСЫН ҮЗЛЭГИЙН ДҮН 2018 он /бүтцээр/



Авто машиныг төрлөөр нь авч үзвэл: 56 хувь буюу 12.6 мянга нь суудлын авто машин, 38.0 хувь буюу 8.6 мянга нь ачааны, 3.0 хувь буюу 765 автобус, 3.0 хувь буюу 726 тусгай зориулалтын авто машин байна.

ЗУРАГ 10. АВТО МАШИНЫ УЛСЫН ҮЗЛЭГИЙН ДҮН / 2015-2018 он/



ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО, РАДИО ЦЭГИЙН ТОО

Холбооны нийт орлого,үүнээс хүн амаас орсон орлого телефон болон радио цэгийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг харуулав.

Нийт орлого Холбооны үйл ажиллагааны нийт орлого гэдэгт цахилгаан холбоо, хөдөлгөөнт холбоо, мэдээллийн технологи, шуудангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж,байгууллагуудын тайлант хугацааны нийт орлогыг оруулна.


Үүрэн телефон хэрэглэгч Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд хөдөлгөөнтэй /нэгээс нөгөө үүрт шилжих/ашиглах боломжтой утасгүй холбооны хэрэглэгч юм.

ХҮСНЭГТ 10. ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ


	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2018/2017
Нийт орлого	сая.төг	392.8	411.2	422.4	403.3	95.4
Хүн амаас олох орлого	сая.төг	148.1	165.8	64.5	47.3	73.3
Телефон цэг	ш	1117	1188	950	912	96.0

2018 онд холбооны нийт орлого 403.3 сая.төг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 4.6 хувиар буюу 19.1 сая төгрөгөөр өссөн байна. Хүн амаас олох орлого нь 47.3 сая.төг болж өнгөрсөн оноос 26.7 хувиар буюу 17.2 сая.төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын 11.7 хувийг хүн амаас орох орлого эзэлж байна.

ЗУРАГ 11. ХОЛБООНЫ САЛБАРЫН НИЙТ ОРЛОГО 2015-2018 он сая.төг



ЗУРАГ 12. ТЕЛЕФОН ЦЭГИЙН ТОО 2015-2018 он



Дүгнэлт, санал

Дотоодын нийт бүтээгдэхүүний урьдчилсан гүйцэтгэлээр 2018 онд Өмнөговь аймаг Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.9 хувь, төвийн бүсийн 19.5 хувь болох 597.4 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагийн дээр нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 8.8 сая төгрөг болж улсын хэмжээнд Орхон аймаг, Улаанбаатар, Дорнод аймгийн дараа 4-т, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дүнгээр 2361.1 тэрбумд хүрчээ. Өмнөговь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2014-2015 онуудад нэлээд бууралттай байсан боловч 2017 онд өндөр өсөлттэй байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар нь авч үзвэл: Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар 21.7 хувь, Аж үйлдвэр, барилгын салбар нь 40.7 хувь, Үйлчилгээний салбар 37.6 хувийг тус тус эзэлж байна.

Нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2014 онд 5.6 сая, 2015 онд 4.6 сая, 2016 онд 6.3 сая, 2017 онд 10.9 сая, 2018 онд 8.8 сая төгрөгт хүрсэн байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2016 оноос 2.5 сая төгрөгөөр өсч, харин өнгөрсөн оноос 2.1 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлын хүрээнд Орон нутгийн дэд бүтцийн хөгжлийг сайжруулах, автозамын сүлжээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, сүүлийн 5 жилд орон нутгийн төсвөөс томоохон хөрөнгө оруулалт хийгджээ.

Барилга угсралт, их засварын ажилд Өмнөговь аймаг 2018 онд 732.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийсэн нь 2017 оноос 1.3 дахин өсч бүсийн дүнд 51.7 хувь, улсын дүнд 18.3 хувийг эзэлж байна.

2011 оноос манай аймагт тээвэр авто замын газар байгуулагдсан нь тээврийн салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах таатай орчинг бүрдүүлсэн. Тус аймгийн тээврийн салбарын дийлэнх хэсэг нь хувьчлагдаж, хувийн тээврийн үйлчилгээ зонхилж байгаа ч шуудан тээврийн үйлчилгээ сэргэж, авто вокзал шинээр баригдаж шинээр нэгдсэн зохион байгуулалтад орж байна. Одоо Улаанбаатар Даланзадгадын чиглэлд өдөр бүр, аймгийн зүүн талын сумдад 7 хоногт 2 удаа зорчигч тээврийн үйлчилгээг нийслэлээс шууд үзүүлдэг, хөдөөгийн сумдад аймгийн төвөөс 7 хоног бүрт 2 удаа шуудан хүрч үйлчилж байна. Иймд тээврийн салбарын үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд жилээс жилд өссөн үзүүлэлтэй байна.

2018 онд 14.5 мян.тн ачаа тээвэрлэж, 4355.3 мян.тн.км-ийн ачаа эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос тээсэн ачаа 423 мян.тн-оор буурч, ачаа эргэлт 15 дахин буурсан гүйцэтгэлтэй байна. Тээвэр бүхий байгууллагууд 2859.7 мян.хүн тээвэрлэж, 90036.4 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос Зорчигч тээвэрлэлт 117.5 хувиар буюу 1544.9 мян.хүнээр өсч, зорчигч эргэлт 47.7 хувиар буюу 82225.2 мян.хүн.км-ээр буурсан гүйцэтгэлтэй байна. Тээврийн орлого 8595.1 сая төгрөг болж өнгөрсөн оноос 32.5 хувиар буюу 4130.7 сая төгрөгөөр буурсан байна.

Сүүлийн жилүүдэд холбоо харилцааны систем эрчимтэй хөгжиж бүх сум шилэн кабелийн сүлжээ, үүрэн холбооны 3-5 операторт холбогдсноор хүссэн цагтаа хэрэгцээт мэдээллээ олж авах, дэлхий аль ч өнцөгт холбоо тогтоох боломж бүрдээд байна. Үүнтэй зэрэгцээд холбооны салбарын үзүүлэлтийн нэг болох суурин утасны тоо жил ирэх тусам унаж байна.

ХОЙШИД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭРХ САНАЛ:

- Шинээр байгуулагдаж байгаа Аж ахуйн нэгж байгууллагууд онцгой зөвшөөрөл авахын тулд 1-2 хүний бүрэлдхүүнтэй ХХК болж үүсч байгаа нь санхүүгийн талаар ямар ч мэдэгдэхүүнгүй нэг гэрийн хоёр хүн дарга, нягтлан гэж бүртгүүлснээс статистикийн мэдээ тайлан гаргах, АШБ хөтлөх талаар ямар ч ойлгоцгүй байна. Иймд ААН Байгууллага шинээр бий болоход тодорхой босго тавьж өгөх шаардлага гарч байна.
- Манай статистикийн 21-ний мэдээ болон холбооны мэдээний хугацаа нь сангийн яамны мэдээний хугацаанаас зөрж байдаг учир аж ахуйн нэгжүүдийн мэдээ тайлан зөрөх тохиолдол гардаг хугацааг адил болгох тал дээр анхаарах нь зүйтэй байна.
- Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг Хойшид үүрэн телефонууд аймагтаа нэгдмэл удирдлаган дор мэдээлэлд хамрагдаж байх нь хуулийн заалтад нийцэх юм.
- Манай аймагт бүртгэлтэй ААНБ-ын удирдлага, санхүүгийн ажилтнууд нь УБ хот болон өөр аймгаас үйл ажиллагаагаа удирдаж явуулж байдаг тээврийн болон уул уурхайн компаниуд байна. Энэ компаниудын мэдээллийг оршин байгаа орон нутгийн статистикийн нэгжээр мэдээллийг авахуулах тал дээр анхаарч ажиллах.

Энэхүү судалгааны хамрах хугацаа нь 2010, 2014, 2015, 2016, 2017, 2018 оны гүйцэтгэлээр харууллаа.

Ашигласан материал:

Жилийн эцсийн мэдээ, тайлан мэдээнүүд

ДНБ-ний тооцоо улс, аймаг, 2015-2018 оны статистикийн эмхтгэл

Хүн ам өрхийн бүртгэлийн сангийн үзүүлэлт зэргийг ашиглав.